


Шифр:.....

Гүйцэтгэх хугацаа: 120 минут

Нийт: 60 оноо

1-р асуулт: Дэлхийн хойд хагас бөмбөрцгийн мөнх цэвдэгт бүс нутагт сүүлийн 100 гаруй жилийн хугацааны агаарын жилийн дундаж температурын өөрчлөлтийн хандлагыг харуулжээ. Тэгвэл 1980 оноос хойш цэвдгийн бүсэд огцом өөрчлөлтүүд илрэх болсон шалтгааныг тайлбарлаж цаашид гарах сөрөг үр дагавруудыг тодорхойлно уу (**Нийт 5 оноо**).



2-р асуулт: Хүснэгтэд Хиаг-хялганат ургамлын бүрхэцийг аж ахуйн бүлгээр (%) бэлчээр ашиглалтаас хамаарч хэрхэн өөрчлөгдөхийг үзүүлэв. Өгөгдсөн даалгавруудыг гүйцэтгэнэ үү (**Нийт 3 оноо**).

№	Ургамлын төрөл	Аж ахуйн бүлгээр, %
1	Үетэн	41.0%
	Буурцагтан	0.1%
	Улалж	23.6%
	Алаг өвс	45.5%
2	Үетэн	75%
	Буурцагтан	2.7%
	Улалж	4.1%
	Алаг өвс	19.2%
3	Үетэн	79.1%
	Буурцагтан	4.4%
	Улалж	1.5%
	Алаг өвс	19.4%
4	Үетэн	41.0%
	Буурцагтан	0.01%
	Улалж	25%
	Алаг өвс	33.9%

ГАЗАРЗҮЙН ОЛИМПИАДЫН XII АНГИЙН II ДАВАА

А. Бэлчээр ашиглалтын хэмжээ нэмэгдэхэд ургамлын төрөлд гарах өөрчлөлтийг товч тодорхойлно уу (1 оноо).

Б. Бэлчээрийн талхлагдлын зэргийг илэрхийлсэн тоог зөв харгалзуулна уу (2 оноо).

Талхлагдлын зэрэг	Харгалзах дугаар
А. Хэвийн	
Б. Сул	
В. Дунд	
Г. Хүчтэй	

3-р асуулт: Хөдөө аж ахуйн газарзүйн салбарт бэлчээрийн ургац, багтаамж, даацыг тогтоох нь чухал асуудал байдаг. Дараах өгөгдсөн даалгавруудыг гүйцэтгэнэ үү (**Нийт 6 оноо**).

А. Бэлчээрийн ургацын хэмжээг тооцоолно уу (3 оноо).

Бэлчээрийн ургамлыг хайчилж нэг ам дөрвөлжин метр талбайн дундаж ургацыг хатааж олсны дараа 1м^2 талбайн ургацын 10 цэгийн дунджаар 24гр гарсан бол 1га дахь ургац хэдэн центнер (ц) болох вэ?

Б. Бэлчээрийн багтаамжийг тооцоолно уу (3 оноо).

Жилд нэг хонин толгой хээрийн бүсэд 5.6ц, ойт хээрийн бүсэд 6ц, говь, өндөр уулын бүсэд 4.2ц гэсэн хэмжээтэй өвс иддэг. Тэгвэл Дорнод аймгийн Халхгол сумын 2-р багийн малчин Н.Ганбатын бэлчээрийн талбай 1800га, бэлчээрийн ургац хуурай жингээр 2.4ц бол өгөгдсөн бэлчээрийн талбайд хэдэн тооны хонин толгой мал бэлчих багтаамжтай вэ?

4-р асуулт: Хүн төрөлхтөн түүхэндээ аж үйлдвэрийн хувьсгалын гурван үе шатыг туулж, эдүгээ дөрөвдөгч хувьсгалтай залгасан. Аж үйлдвэрийн хувьсгалын үе шатуудын томоохон дэвшлүүд нь тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн шинэ өөрчлөлтийг бий болгосон байдаг. Хүснэгтэд аж үйлдвэрийн хувьсгалын үе шатуудын гол дэвшлүүдийг нөхөж бичнэ үү (**Нийт 4 оноо**).


№	Аж үйлдвэрийн үе шатууд	Гол дэвшлүүд
1	Анхдугаар хувьсгал	
2	Хоёрдугаар хувьсгал	
3	Гуравдугаар хувьсгал	
4	Дөрөвдүгээр хувьсгал	

6-р асуулт: Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 5.3.2-р зүйлд “Тариалангийн талбайд кадастрын зургийг 1:25 000-аас багагүй масштабаар үйлдэнэ” гэж заасан байдаг ба уг хуулийн 5.4 зүйлд “Кадастрын зургийн нарийвчлал нь тухайн масштабын 0,1мм-т ногдох хэмжээнээс ихгүй байна” гэж заасан байдаг. Тэгвэл тариалангийн талбайн 1:25 000-ны масштабтай кадастрын зургийн нарийвчлалыг тооцоолно уу (**Нийт 3 оноо**).

Зөвлөмж: Нэгж эзэлхүүнтэй агаарт агуулагдах усны уурын тоо хэмжээг граммaар илэрхийлсэн үзүүлэлтийг үнэмлэхүй чийгшил гэнэ. Дальтоны хууль ёсоор агаарын найрлага дахь хий бүр хувийн (парциаль) даралттай бөгөөд тэдгээрийн нийлбэр нь агаарын даралттай тэнцүү байдаг. Агаарын даралтанд усны уурын зүгээс үзүүлж буй парциаль даралтын хэмжээг усны уурын парциаль даралт гэнэ. Үнэмлэхүй чийгшил болон усны уурын парциаль даралтын хоорондын холбоог илэрхийлсэн харьцааг санах хэрэгтэй.

ГАЗАРЗҮЙН ОЛИМПИАДЫН XII АНГИЙН II ДАВАА

8-р асуулт: Зурагт тоогоор дугаарласан боомтуудыг нэрлэж, хүснэгтэнд мэдээллийг нөхнө үү (Нийт 8 оноо).



№	Хилийн боомтын нэр	Байршил	Хөрш боомт
1			ОХУ-ын Шарсуурь
2		Хөвсгөл, Ханх	
3		Дорнод, Чулуунхороот	
4			БНХАУ-ын Зүүн хатавч
5		Өмнөговь, Ханбогд	
6			БНХАУ-ын Лаомяо
7			БНХАУ-ын Такашкен
8		Баян-Өлгий, Ногооннуур	

9-р асуулт: Туул голын сав дагуух хар хүрэн хөрсний шинж чанарын 30 жилийн өөрчлөлтийг (1987-2017) хүснэгтэд харуулжээ. Хүснэгтэд дөрвөлжин хүрээгээр тодруулсан хэсэгт хөрсний органик бодисын өөрчлөлт илэрсэн байна. Энэ өөрчлөлтийг үүсгэж буй байгаль, нийгмийн хүчин зүйлийг тодорхойлно уу (Нийт 4 оноо).

.....

.....

.....

ГАЗАРЗҮЙН ОЛИМПИАДЫН XII АНГИЙН II ДАВАА

Он	Газар	Зүсэлт №	Гүн см.	pH (1:2.5)	Органик бодис %	CaCO ₃ %
1987	Алтанбулаг	27	0-11	8.20	3.710	0.00
		28	0-6	8.20	3.790	0.00
		34	0-20	6.40	1.550	0.00
	Овоот	36	0-12	7.10	2.450	0.00
		37	0-20	7.30	0.700	0.05
		44	0-10	7.70	2.930	0.98
	Лүн	45	0-20	7.80	1.460	0.00
		46	0-5	6.80	0.840	0.00
		48	0-12	8.00	3.620	0.72
		49	0-16	8.10	2.150	0.68
		Дундаж		7.56	2.32	0.24
2017	Алтанбулаг	27	0-11	7.53	3.678	0.00
		28	0-6	7.39	3.743	0.00
		34	0-20	6.54	1.093	0.00
	Овоот	36	0-12	6.95	2.068	0.00
		37	0-20	6.90	0.998	0.00
		44	0-10	7.46	2.642	1.20
	Лүн	45	0-20	7.30	1.354	0.00
		46	0-5	7.20	0.762	0.00
		48	0-12	8.26	2.678	0.51
		49	0-16	7.81	1.796	0.29
		Дундаж		7.33	2.08	0.20

10-р асуулт: Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн урд байрлах цэцэрлэгт хүрээлэнгийн ялгаатай цаг хугацааны сансрын зургийг ашиглан дараах даалгавруудыг гүйцэтгэнэ үү (**Нийт 8 оноо**).

А. Сансрын зургийг хэрэглээний үндсэн ач холбогдол юу вэ? (4 оноо)

Б. Сансрын зурагт гарсан өөрчлөлтүүдийг гурвалжин дүрсээр тэмдэглэнэ үү (1 оноо)


Улаанбаатар хотын Сүхбаатарын талбай
Хонхтой цэцэрлэгт хүрээлэн
2020 оны 4-р сар 30-ны өдөр



А

1 см = 8.83 метр

Улаанбаатар хотын Сүхбаатарын талбай
Хонхтой цэцэрлэгт хүрээлэн
2020 оны 9-р сар 30-ны өдөр



Б

1 см = 8.83 метр

В. Бүтээн байгуулалтын үед $572,13\text{м}^2$ талбайн хөрс эвдрэлд орж, үржил шимт хөрсөөр 30см зузаантайгаар нөхөн сэргээлт хийсэн гэж үзвэл шаардлагатай хөрсний хэмжээг тооцоолно уу (3 оноо).

.....

.....

.....

.....


ГАЗАРЗҮЙН ОЛИМПИАДЫН XII АНГИЙН II ДАВАА

11-р асуулт: Нийслэлээ нүүлгэсэн улсуудыг зөв харгалзуулна уу (**Нийт 4 оноо**)

Хуучин нийслэл	Шинэ нийслэл	Улсын нэр
1. Карачи	А. Бразилиа	А. Танзани
2. Лагос	Б. Абужа	Б. Бразил
3. Дар эс Салам	В. Исламабад	В. Нигери
4. Рио-де-Жанеро	Г. Додома	Г. Пакистан

Хариулт: 1.....2.....3.....4.....

12-р асуулт: Байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр үүссэн ой, хээрийн түймрийн гаралтын сүүлийн 21 жилийн орон зайн тархалтыг зургаар харуулав. Энд түймрийн гаралт Монгол орны зүүн 3 аймагт яагаад их давтагдалтай гардаг шалтгааныг тайлбарлана уу (**Нийт 2 оноо**)



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....